



Монголын яаралтай тусламжийн нийгэмлгийн
тэргүүний 2016 оны 05 дугаар сарын 10 өдрийн тушаал

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Энэхүү тусгай шаардлагыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл зөвшөөрсөн өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай мөрдөнө.

- 1. Яаралтай тусламжийн мэргэшлээр АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:**
 - 1.1 Яаралтай тусламжийн мэргэжлээр 8 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан;
 - 1.2 Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгийн үйл ажилагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, түүнийгээ тодорхойлох (баримт хавсаргах), идэвхи санаачлагатай байх;
 - 1.3 Бүтээлийн жагсаалтанд яаралтай тусламийн нийгэмлэгийн “Яаралтай тусламж” сэтгүүл (хамгийн багадаа 1) болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 2-оос доошгүй илтгэл (онол практикийн хуралд) хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана;
 - 1.4 Эмчлэх тусламж үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон, мэргэжлийн алдаа дутагдал гаргалгүй ажилласан байх; (зэргийн шалгалтанд орохыг зөвшөөрсөн байгууллагын тодорхойлолтод энэ талаар тусгасан байх)
 - 1.5 Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд яаралтай тусламж мэргэжил дээшлүүлэх сургалтанд 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх, түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах;
 - 1.6 Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэжлийн сэргалтанд тогтмол хамрагдсан байх; (нийгэмлэгийн болон мэргэжлийн сургалтанд оролцсон гэрчилгээний хуулбарууд)
 - 1.7 Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх;
 - 1.8 Мэргэжлээрээ ажилласан 8 жилд хийсэн ажлын тайлан; (товч тоон үзүүлэлтээр)
- 2. Яаралтай тусламжийн мэргэшлээр ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:**
 - 2.1 Яаралтай тусламжийн мэргэшлээр ахлах зэрэг авснаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан;

- 2.2 Монголын яаралтай тусlamжийн нийгэмлэгийн үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, түүнийгээ тодорхойлох (баримт хавсаргах), идэвхи санаачлагатай байх;
 - 2.3 Бүтээлийн жагсаалтанд яаралтай тусlamжийн нийгэмлэгийн “Яаралтай тусlamж” сэтгүүл (хамгийн багадаа 2) болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 3-оос доошгүй өгүүлэл (онолын, тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлж, 5-с доошгүй (онол практикийн хуралд) хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана;
 - 2.4 Эмчлэх тусlamж үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон, мэргэжлийн алдаа дутагдал гаргалгүй ажилласан байх; (зэргийн шалгалтанд орохыг зөвшөөрсөн байгууллагын тодорхойлолтод энэ талаар тусгасан байх)
 - 2.5 Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд яаралтай тусlamжийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх; (түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах)
 - 2.6 Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэжлийн сургалтанд тогтмол хамрагдсан байх; (нийгэмлэгийн болон мэргэжлийн сургалтанд оролцсон гэрчилгээний хуулбарууд)
 - 2.7 Суралцагч эмч (резидент) мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшүүлсэн, нийгэмлэгээс зохиосон сургалтын ажилд идэвхитэй оролцсон байх;
 - 2.8 Эмнэлзүйн сургагч багшийн сургалтанд хамрагдаж дүүргэсэн байх; (түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах)
 - 2.9 Залуу эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдэд ажлын байрны богино хугацааны сургалтанд хичээл заадаг; (хичээлийн хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах)
 - 2.10 Эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх;
 - 2.11 Гадаад хэлний зохих мэдлэгтэй, түүнийгээ нотлох баримтыг (үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал) хавсаргана;
 - 2.12 Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан (товч тоон үзүүлэлтээр)
3. Яаралтай тусlamжийн мэргэжлээр **ЗӨВЛӨХ** зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. **Үүнд:**
 - 3.1 Яаралтай тусlamжийн мэргэшлээр тэргүүлэх зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан;
 - 3.2 Сум дундын эмнэлэгт яаралтай тусlamжийн эмчээр тогтворт суурьшилтай, тасралтгүй 20 ба түүнээс дээш жил ажилласан, тусгай хангасан бол зөвлөх зэрэг горилж болно.

- 3.3 АШУ эсвэл АҮ-ын магистр, клиникийн профессор (хоёулаа байх) цолтой байх;
- 3.4 Монголын яаралтай тусlamжийн нийгэмлэгийн үлгэр жишээч гишүүн байх, үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, нийгэмлэгээс зохиосон сургалтыг ажилд идэвхитэй оролцсон байх;
- 3.5 Өмнөх зэрэг хамгаалснаас хойших бүтээлийн жагсаалт гаргах. Үүнд:
- 3.5.1 Монголын яаралтай тусlamжийн нийгэмлэгийн “ Яаралтай тусlamж” сэтгүүл (хамгийн багадаа 3) болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 3-оос доошгүй өгүүлэл (онолын, тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлсэн;
 - 3.5.2 8-с доошгүй (онол практикийн хуралд) хэлэлцүүлсэн байх; (дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж гарчиг ба өгүүлэл, илтгэл хавсаргана)
 - 3.5.3 Өөрөө бичиж хэвлүүлсэн ном болон хамтран бүтээсэн номын тоо 2-оос доошгүй байх;
 - 3.5.4 Хамтран гаргасан баталгаажуулсан оношилгоо, эмчилгээний удирдамж; (түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах)
 - 3.5.5 Зохиогчийн эрх, ашигтай заавар, оновчтой саналын гэрчилгээний аль нэгийг авсан байх; (түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах)
 - 3.5.6 Эмнэлзүйн практикт бодитоор нэвтрүүлж үр дүнгээ өгсөн шинэ арга 2-оос доошгүй байх; (түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах)
- 3.6 Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэж ирсэн, энд дурдагдсан тусгай шалгуурыг ханган биелүүлж, хамт олондоо хүндлэгдсэн үлгэр жишээчээр ажиллаж байгаа, зөвлөх зэргийн шалгалтанд орохыг зөвшөөрсөн байшууллагын тодорхойлолтод энэ талаар тусгасан байх;
- 3.7 Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд яаралтай тусlamжийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх; (түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах)
- 3.8 Эмнэлзүйн сургагч багш болон эмнэлзүйн чиглүүлэгч багшийн сургалтанд хамрагдаж дүүргэсэн байх; (аль нэг нь байж болно, түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах)
- 3.9 Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэжлийн сургалтанд тогтмол хамрагдсан байх (нийгэмлэгийн болон мэргэжлийн сургалтанд оролцсон гэрчилгээний хуулбарууд)
- 3.10 Суралцагч эмч (резидент) мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшиүүлсэн, залуу эмч, сувилагчийн сургалтанд оролцож хичээл заадаг; (хичээлийн хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах)

- 3.11 Мэргэжлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн, өөрийгөө орлох хэмжээний шавь нарыг бэлтгэсэн байх;
- 3.12 Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх;
- 3.13 Англи хэлний зохих мэдлэгтэй, түүнийгээ нотлох баримтыг (үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал) хавсаргана.
- 3.14 Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан; (товч тоон үзүүлэлтээр гаргах)